



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/493 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, үнэлгээ хийх хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус ажлыг 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор гүйцэтгэж, Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсэг (Р.Энхсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн гишүүдийн илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах нягтлан бодогч (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дарга Захиргаа, удирдлагын газрын дарга (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЗЭНДМАА

• 1423 010057

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 23 дугаар сарын 2 өдрийн
15/3 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН
АШИГЛАЛТАД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын дарга

Гишүүд:

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт
тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт
тохируулгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Яамны харъяа эрүүл мэндийн байгууллагын
эмнэлгийн тоног, төхөөрөмжийн шалгалт,
тохируулгын асуудал мэргэжилтэн

Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн засвар тохируулгын асуудал
хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны, Санхүү, эдийн засгийн
Газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн Төсөл,
хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан
мэргэжилтэн (Зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл,
судалгаа, мэдээллийн сангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 27 өдрийн
А/57 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АШИГЛАЛТАД ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2023.03.22

Нэг. Үндэслэл

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.8.9-д “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.5-д “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн програм хангамжийн ашиглалтад үнэлгээ хийх, программын шинэчлэлт /хөгжүүлэлт/ хийх” гэсэн ажил тус тус тусгагдсан.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн G0236: Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - IV төслийн санхүүжилтээр эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн программ хангамж хийгдэж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/493 дугаар тушаалаар “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам” батлагдсан. Мөн 2018 онд “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн системийн программын гарын авлага”, 2019 онд “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн олон улсын нэр томъёоны толь бичиг”-ийг тус тус хэвлүүлж, хэрэглэгчдэд хүргүүлсэн. Мөн програмын ашиглалтын сургалтыг 2017, 2018 онуудад танхим болон цахимаар зохион байгуулсан. Гэвч тус программын ашиглалт эрүүл мэндийн байгууллага тус бүрт харилцан адилгүй байгаа нь тоног төхөөрөмжийн бүртгэл, түүнд суурилсан хөрөнгийн төлөвлөлт, шаардлагатай тооцоо судалгааг хийхэд ихээхэн хүндрэлтэй байна. Иймд эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийх, өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлагыг тодорхойлох;

Гурав. Зорилт

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн программын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх;
2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалт болон санд оруулсан мэдээллийн бүрэн байдлыг үнэлэх;
3. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэхэд цаашид авах арга хэмжээг тодорхойлох;

Дөрөв. Үйл ажиллагаа

1. Хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллага дээр очиж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн программын хэрэглэгчээс Google Form ашиглан сэтгэл ханамжийн судалгаа авна.

2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалт болон санд оруулсан мэдээллийн бүрэн байдлыг үнэлнэ.
3. Үнэлгээний явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэхэд цаашид авах арга хэмжээг тодорхойлж, тайлан боловсруулна.
4. Үнэлгээний тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.

Тав. Хамрах хүрээ

Эрүүл мэндийн яамны харьяа 19, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 21 буюу нийт 40 эрүүл мэндийн байгууллага үнэлгээнд хамрагдана.

Зургаа. Хугацаа

2023 оны 04 дүгээр сарын 18-аас 06 дугаар сарын 30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Үнэлгээний бүрэлдэхүүн

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэргэжилтнүүд.

Найм. Хүлээгдэж буй үр дүн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн ашиглалтад үнэлгээ хийж, өнөөгийн байдал болон цаашид авах арга хэмжээг тодорхойлж, шийдвэр гаргагчид мэдээллээр хангагдсан байна.

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ПРОГРАММЫН
ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ АСУУМЖ**

Эмнэлгийн нэр:

№	Асуумж	Үнэлгээ
1	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн программын сургалтад хамрагдсан эсэх	Тийм/Үгүй
2	Сургалтад хэдэн удаа хамрагдсан вэ?	1,2,3,4
3	Сургалт хэр үр дүнтэй болсон вэ?	
4	Мэдээллийн сангийн программыг ашиглаж байгаа юу?	Тийм/Үгүй
5	Мэдээллийн сангийн программд бүртгэл хийх компьютер хүрэлцээтэй эсэх	Тийм/Үгүй
6	Хэдэн ажилтанд хэдэн компьютер байдаг вэ?	
7	Мэдээллийн сангийн программд хамгийн сүүлд хэзээ тоног төхөөрөмж бүртгэсэн вэ?	
8	Мэдээллийн сангийн программд ямар цахим хаягаар орохыг мэддэг эсэх	Тийм/Үгүй
9	Мэдээллийн сангийн программд нэвтрэх нэр, нууц үгээ мэдэх үү?	Тийм/Үгүй
10	Мэдээллийн сангийн программын тоног төхөөрөмжийн бүртгэлийн хэсгээс бусад хэсгийг ашигладаг уу?	Тийм/Үгүй
11	Ашигладаг бол доорхи хэсгийн алийг ашигладаг вэ?	
11.1	Шалгалт тохируулга	
11.2	Техник ашиглалтын паспорт	
11.3	Мэдээлэл	
11.4	Тайлан, шинжилгээ	
12	Доорх хэсгүүдийн ажиллагаанд үнэлгээ өгнө үү	
12.1	Шалгалт тохируулга	
12.2	Техник ашиглалтын паспорт	
12.3	Мэдээлэл	
12.4	Тайлан, шинжилгээ	
13	Мэдээллийн сангийн программд тоног төхөөрөмж бүртгэхэд хүндрэл байдаг уу? Тийм бол доорхи хэсгээс сонгоно уу	Тийм/Үгүй
13.1	Гацдаг	
13.2	Мэдээлэл оруулахад ойлгомжгүй	
13.3	Олон асуумжтай	
13.4	Интернетгүй үед ашиглах боломжгүй	
13.5	Гар утас, таблет дээр ашиглах боломжгүй	
13.6	Бусад	
14	Цаашид мэдээллийн сангийн программыг хэрхэн хөгжүүлэхийг хүсэж байна вэ? Санал бичих	

Тайлбар: 12.1-12.4 дүгээрт үнэлгээгээр үнэлгээ өгөхдөө сайн - 3, дунд - 2, муу - 1 гэж үнэлнэ

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН
АШИГЛАЛТЫГ ҮНЭЛЭХ АСУУМЖ**

№	Үнэлгээ хийсэн программын хэсэг	Нэвтрэн орох	Хэсгийн ажиллагаа	Мэдээлэл оруулах, хадгалах	Тулгамдаж буй асуудал
1	heps.hdc.gov.mn				
2	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл				
3	Шалгалт тохируулга				
4	Техник ашиглалтын паспорт				
5	Мэдээлэл				
6	Байгууллага				
7	Лавлах				
8	Системийн тохиргоо				
9	Шинжилгээ				
10	Тайлан				

Тайлбар: Программын ажиллагааг доорх үнэлгээгээр үнэлнэ үү ордоггүй - 1, гацаж ордог - 2, ордог мэдээлэл хадгалдаггүй алдаа заадаг - 3, хэвийн ажилладаг - 4

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНД ОРУУЛСАН
МЭДЭЭЛЛИЙН БҮРЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ АСУУМЖ**

№	Асуумж	Үнэлгээ
1	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/493 дугаар тушаалаар батлагдсан Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмын 4.4.1 дугаарт заасны дагуу тоног төхөөрөмжийн мэдээлэл бүртгэх ажилтныг томилсон эсэх	
2	Системд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо	
3	Одоо ажиллаж байгаа системд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо	
4	Ажлаас гарсан инженер, техникчийн эрхийг устгуулсан эсэх	
5	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт тоног төхөөрөмжийн тоо	
6	Системд бүртгэсэн нийт тоног төхөөрөмжийн тоо	
7	2022-2023 онд бүртгэсэн тоног төхөөрөмжийн тоо	
8	Сүүлд бүртгэл хийсэн он	
9	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн талбарыг үнэн зөв, бүрэн бүртгэсэн хувь /дундаж/	
9.1	Тасаг	
9.2	UMDNS код	
9.3	Бүтээгдэхүүний нэр	
9.4	Үйлдвэрлэсэн улс	
9.5	Үйлдвэрлэгч	
9.6	Үйлдвэрлэсэн огноо	
9.7	Загвар	
9.8	Серийн дугаар	
9.9	Ашиглалтад орсон огноо	
9.10	Өртөг	
9.11	Санхүүжилт	
9.12	Нийлүүлэгч	
10	Техник ашиглалтын паспорт бүртгэсэн хувь /дундаж/	
10.1	Урьдчилсан үзлэг	
10.2	Техник үйлчилгээ	
10.3	Засвар үйлчилгээ	
10.4	Гэмтсэн төхөөрөмж	
10.5	Техникийн цаг ашиглалт	
11	Эрүүл мэндийн байгууллаганы мэдээллийг бүрэн оруулсан эхэс /дундаж/	
11.1	Байгууллаганы нэр	
11.2	Засаг захиргаа	
11.3	Сум, дүүрэг	
11.4	Байгууллагын регистрийн дугаар	
11.5	Улсын бүртгэлийн дугаар	
11.6	Шатлал	
11.7	Хаяг	
11.8	Утас	
11.9	Орны тоо	
	Систем ашиглалтын дундаж үнэлгээ	

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 31 өдрийн
4/57 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АШИГЛАЛТАД
ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХУВААРЬ**

№	Байгууллагын нэр	Үнэлгээ хийх хугацаа
Эрүүл мэндийн яамны харъяа байгууллага		
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	2023.04
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	2023.04
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	2023.04
4	Халдварт өвчин судлалын үндэсний төв	2023.04
5	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	2023.04
6	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	2023.04
7	Хавдар судлалын үндэсний төв	2023.04
8	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	2023.04
9	Эмгэг судлалын үндэсний төв	2023.04
10	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв	2023.04
11	Арьсны өвчин судлалын үндэсний төв	2023.05
12	Зоонозын өвчин судлалын үндэсний төв	2023.05
13	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	2023.05
14	Геронтологийн үндэсний төв	2023.05
15	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	2023.05
16	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	2023.05
17	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	2023.05
18	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	2023.05
19	Хүүхдийн төв сувилал	2023.05
Нийслэлийн эрүүл мэндийн газрын харъяа байгууллага		
1	Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2023.05
2	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2023.05
3	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2023.05
4	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг	2023.05
5	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
6	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
7	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
8	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
9	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
10	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
11	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.05
12	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	2023.04
13	Шүд эрүү нүүрний төв	2023.04
14	Наркологийн эмнэлэг	2023.04
15	Түргэн тусламжийн төв	2023.04

16	Сэргээн засах клиник		2023.04
17	Энэрэл эмнэлэг		2023.04
18	Хонхор Тосгоны Эрүүл мэндийн төв		2023.04
19	Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төв		2023.04
20	Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв		2023.04
21	Туул тосгоны Эрүүл мэндийн төв		2023.04